


## Агааржуулагчтай сайжруулсан нүхэн жорлон гэж юу вэ?

Битүүмжлэл сайтай бүхээгтэй, агааржуулалтын хоолойтой, хөрсний нөхцлөөс хамааран нүхийг энгийн болон хүчигтгэж доторлосон ариун цэврийн байгууламж юм.

### Онцлог:

- Энгийн жорлонтой харьцуулахад үнэр, ялаа эрс бага
- Усны эх үүсвэр шаардлагагүй
- Материалын олдоц сайн, барихад хялбар
- Битүү доторлосон тохиолдолд дахин нүх ухах шаардлагагүй
- Уламжлалт жорлонтой ижил тул хэрэглээ, үйлчилгээ энгийн
- Гадаа байрлах тул өвөл хүйтэн



## Бага хэмжээний усаар зайлцуулах жорлон гэж юу вэ?

Энэ жорлон нь ялгадсыг усан хаалт бүхий суултуураас усны ургалаар хөөх зарчмаар ажилладаг. Усны хэрэглээгээр нь нэг удаад 2-3л ус хэрэглэдэг зөөврийн устай, 4л-ээс их хэмжээний ус хэрэглэдэг гүний худагтай холбогдсон гэж 2 ангилаа.



### Онцлог:

- Бүхээгийг байшин дотор байрлуулж болох тул тохилог
- Ялгадсыг усаар зайлцуулах тул үнэргүй, цэвэрхэн
- Соруулах боломжтой тул дахин нүх ухах шаардлагагүй
- Ялгадасыг суллуулахад зардал гарна
- Усны эх үүсвэр шаардлагатай

## Хэрэглээ үйлчилгээ

- Керамик, хуванцар суултуур хэрэгтэй.
- Суултуур болон холбох хэрэгсэл нь шаланд бэхлэгдсэн байна.
- Шалыг бага зэрэг налуу хийх нь усны урсацыг сайжруулдаг.
- Бүхээг нь нүхний хажууд байрласан жорлонг барилга дотор байрлуулж болох ба энэ тохиолдолд агааржуулагчийн хоолойг байшингийн дээвэрээс өндөр хийнэ.

## Хэрэглээ үйлчилгээ

- Бүхээгийн эргэн тойронд хаяавч хийх нь нүх рүү бороо, үерийн ус орохоос сэргийлнэ. Хаяавч цоорч бүрэн бүтэн байдал алдагдвал битүүлнэ.
- Жорлонгийн шал, дотор ханыг тогтмол угааж цэвэрлэнэ.
- Нүхэнд ариун цэврийн хэрэглэл, хог хаягдал, хийхийг хориглоно.

## Суллах зайлцуулах

Нүх амсраас доош 0.5м хэмжээнд хүртэл дүүрсэн үед ялгадсыг холбогдох журмын дагуу зайлцуулж нүхийг халдвартайжүүлэн дахин ашиглана.

## Суллах зайлцуулах

Нүх стандартад заасан хэмжээнд хүртэл дүүрсэн үед

- Ялгадсыг соруулж зохих журмын дагуу зайлцуулна.
- Хоёр нүхтэй тохиолдолд нөгөө нүхийг ашиглана.

## Бордоожуулах жорлон гэж юу вэ?

Бордоожуулах жорлон нь ялгадсыг үртэс, сүрэл зэрэг нүүрстөрөгчөөр баялаг материалтай хольж ялзруулан үнэргүй, аюулгүй бордоо болгодог жорлон юм.

### Онцлог:

- Усны эх үүсвэр шаардлагагүй
- Хөрс бохирдуулахгүй
- Нүх ухахад хэцүү намагтай, чулуутай газар илүү тохирно
- \* Үнэргүй, цэвэрхэн, тохилог
- Айл өрх өөрсдөө бордоо хийхгүй зөвхөн нэгдсэн үйлдвэрт бордоо хийнэ.
- Суллуулах зардал гарна
- Зөв ашиглаж хэвшихэд мэдлэг, дадал шаардагдана

## Хэрэглээ үйлчилгээ

- Бүхээгт жижиг ширхэгтэй органик материал (үртэс, хар шороо гэх мэт) хийсэн хувин байрлуулж, бие засссаны дараа ялгадсыг хучиж өгнэ.
- Өтгөн шингэнийг тусгаарлах суултууртай тул өтгөн хураах хэсэгт шээхгүй, угаадас хийхгүй байх.
- Төрөл бүрийн химийн бодистой ус нь ялгадас задрах явцыг удаашруулдаг тул суултуурыг зөвхөн усаар угааж цэвэрлэх.
- Өтгөнийг задралд оруулж бордоо болгох тул элдэв хог хаягдалтай холихгүй байх.

## Суллах зайлцуулах

Өтгөн хураах сав дүүрсэний дараа нэгдсэн суллах үйлчилгээнд хамрагдаж ялгадсыг зайлцуулна.

# Хуурайшуулах жорлон гэж юу вэ?

Хуурайшуулах жорлон нь ялгадсыг суурийн хоёр тасалгаанд ээлжлэн хурааж агааржуулалт болон уртэс, үнс гэх мэт нэмэлт хуурай бодисын тусламжтайгаар усгүйжүүлж, хатаах технологитой

## Онцлог:

- Хоёр тасалгааг ээлжлэн хэрэглэх тул удаан хугацаанд ашиглана
- Усны эх үүсвэр шаардлагагүй
- Үнэргүй, ялаагүй
- Зах зээлд олдоцтой материалыар барих боломжтой
- Нүх ухахад хэцүү чулуутай, намагтай газар илүү тохирно
- Дүүрсэн үед ялгадсиг суллах, суултуурыг зөөх гэх мэт ажиллагаа шаардлагатай
- Зүй зохистой хэрэглэхийн тулд мэдлэг, дадал шаардлагатай.

## Хэрэглээ үйлчилгээ

- Суурийн эхний тасалгаа ялгадсаар дүүрэх үед суултуурын нүхийг сайтар таглан орхиж нөгөө тасалгааг ашиглана.
- Хоёр дахь тасалгааг дүүрэх үед эхний тасалгаан дахь ялгадас хатаж хуурайшсан байна. Үүнийг суллаж аваад тухайн тасалгааг дахин ашиглаж эхлэнэ. Энэ маягаар ээлжлэн ашиглана.
- Нүх ухах боломжгүй газар илүү тохиромжтой
- Суурин дотор угаадас, элдэв хог хаягдал хийхийг хориглоно.

## 5.5 Суллах зайлуулах



Та бүхнийг хэрэгцээндээ нийцсэн орчиндоо тохирсон цэвэрхэн, тохилог ариун цэврийн байгууламж барьж ашиглахад тань дараах мэдээллийн эх үүсвэрүүд тус болно.

[www.washaction.mn](http://www.washaction.mn)  
[www.mohs.mn](http://www.mohs.mn)  
[www.phi.gov.mn](http://www.phi.gov.mn)  
[www.redcross.mn](http://www.redcross.mn)



Ариун цэврийн  
байгууламжийн хувилбарууд


MNS 5924 : 2015

# Ариун цэврийн байгууламжийн ерөнхий шаардлага



## Нүх

- ▶ Жорлонгийн нүх хөрсний уснаас дээш 2м-ээс багагүй түвшинд байна.
- ▶ Хөрсний усны түвшин өндөр, намагтай газар нүхийг хүчтгэж доторлоно.
- ▶ Хүчинтгэсэн доторлогоотой нүх нь ээлжлэн ашиглах зэрэгцээ нүхтэй байж болно.
- ▶ Хад чулуутай хөрсөнд нүхийг хүзүүвч хэлбэрээр газраас дээш өндөрлөж болно.
- ▶ Нүхний эзэлхүүнийг ашиглах хүний тоо, ашиглахаар төлөвлөсөн жил, суурь коэффициент 0,06м<sup>3</sup>-ийн үржвэрээр тооцоолно.
- ▶ Нүхэнд ариун цэврийн хэрэглэл, хог хаягдал хийхгүй байх нь зүйтэй.



## Шал

- ▶ Бүхээгний шалыг суулгахдаа ачаалал даах материалыаар дамнуурга хийнэ. Дамнуургыг нүхний доторлоогүй амсраас 150мм, хөрсний түвшингээс 100мм-ээс багагүй байхаар ухаж байрлуулна.
- ▶ Шалыг 50мм-ээс багагүй зузаан материалыаар зайд завсаргүй шалланна. Эсвэл бетон хавтангаар хийж болно.
- ▶ Шалны дунд бие засах нүх гаргаж, суух гишгүүр байрлуулна. Бие засах нүхний урт 380мм, өргөн 250мм зууван хэлбэртэй байна.
- ▶ Бүхээгний ар хананаас нүхний ирмэг хүртэл 180мм байна.
- ▶ Хүүхдийн жорлонгийн бие засах нүхний урт 280мм, өргөн 180мм байна.



## Бүхээг

- ▶ Бүхээгийн хана дээвэр зайд завсаргүй, хаалга бүрэн онгойж хаагддаг, цэвэр, өнгө үзэмжтэй байна.
- ▶ Хэмжээ: Нуурэн талын өндөр 2,4м, ар талын өндөр 2,1м, хажуу талын өргөн 1,2м байна.
- ▶ Хаалгыг нарны тусгалын эсрэг харуулж байрлуулна. Хаалганы дээд талд 400мм x 200мм торчийн цонх гаргана.
- ▶ Бүхээгний хаалга гадна дотор талдаа түгжээтэй, шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байна.



## Агааржуулалт

- ▶ Жорлон заавал агааржуулалтын хоолойтой байна
- ▶ Хоолой нь арын хананы дунд хэсэгт, нүхний харалдаа байрлана.
- ▶ Хоолойн өндөр бүхээгний арын хананы өндрөөс 200мм-ээс багагүй өндөртэй, 200мм-ийн голчтой байна.
- ▶ Хоолойн дээд үзүүрт ялааны тор, малгайвчтай байна.
- ▶ Агааржуулах хоолойг хар өнгөр будах нь агааржуулах явцыг дэмжинэ.

# Хүрээлэн буй орчны шаардлага

Ариун цэврийн байгууламжийг нийтийн эзэмшлийн газар, үерийн ус буудаг газарт барихыг хориглоно.

Нүхэн жорлонг ноёлох салхины доод талд доор дурьдсан хэмжээнээс багагүй зайд барьж байгуулна.

Голын эрэг,  
усны эх үүсвэр



200м

Үйлчилгээний газар,  
орон сууц



20м

Ариун цэврийн  
байгууламжийн



Ус түгээх цэг, гүний  
худаг



25м



8м

## Эрүүл ахуйн шаардлага

- ▶ Бүхээгийг ариутгаж, цэвэрлэх боломжтой материалыар доторлох.
- ▶ Бүхээгт ариун цэврийн цаас, өлгүүр, тагтай хогийн сав, цэвэрлэгээний хэрэгсэл байна.
- ▶ Ариутгал цэвэрлэгээний бодис хэрэгслийг бага насны хүүхдийн гар хүрэхгүй газар байрлуулна.
- ▶ Бүхээгний шалыг цэвэрлэж ариутгах боломжтой, хальтиргаа гулгаанаас хамгаалсан материалыар өнгөлнө.
- ▶ Бие засах нүх зориулалтын тагтай байх бөгөөд хэт халуун болон шөнийн цагаар таглаж, салхитай өдөр онгорхой байлгавал зохино.

## Нүхийг суллах, ариутгах, дахин ашиглах, буулгах шаардлага

- ▶ Суурин нүхний эзэлхүүний 90% нь ялгадсаар дүүрэх үед соруулах буюу суллаж бохирыг холбогдох журмын дагуу зайлцуулна.
- ▶ Жилд 2 удаа нүхийг суллаж, бохирыг зайлцуулах, ариутгах ажлыг гүйцэтгэнэ.
- ▶ Дахин ашиглах боломжгүй жорлон, угаадасны нүхний бохирдсон хөрсийг зайлцуулж халдвартгуйжүүлэлт хийн эрүүл хөрсөөр дүүргэж ариутгана.

Таньд санал болгож буй эдгээр жорлонгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах цахим хуудсуудад хандаарай.

[www.washaction.mn](http://www.washaction.mn)

[www.phi.mn](http://www.phi.mn)


[www.redcross.mn](http://www.redcross.mn)



СТАНДАРТАД  
НИЙЦСЭН  
жорлонгийн  
шинэ шийдлүүд

## Онцлог

Жорлонгийн нүхийг хөрс бохирдуулахгүйгээр битүү доторлосон. Ар талд нь дүүрсэн үед суплаж байх таг гаргасан. Бүхээг битүүмжлэл сайтай мөн агааржуулагчтай.



## Хийц бүтээц

Нүхний эзэлхүүнийг ашиглах хүний тоо, ашиглахаар төлөвлөсөн жил, 0,06м3-ийн үргжвэрээр тооцно.

Бүхээг : Урд талын өндөр 2.4м,

Арын өндөр 2.1м,

Хажуу талууд 1.2м

Агааржуулагч: 2,5м, Ø200см

Бие засах нүх: 38см x 25см зууван хэлбэртэй байна.

## Ашиглаж болох материал

Бүхээг: модон хавтан, банд, магнезит хавтан  
Агааржуулагч: PVC хоолой  
Нүх: хүчинтгэж доторлоно

## Онцлог

Био жорлон нь ялгадсыг үртэс, сүрэл, органик ногоон хаягдалтай хольж ялзруулан, үнэргүй, аюулгүй бордоо болгодог жорлон юм.

## Хийц бүтээц

Нүх, Суурь, Бүтээг гэсэн 3 хэсэгтэй.

Бүхээг: Урд талын өндөр 2.4м,


Арын өндөр 2.1м,

Хажуу талууд 1.2м

Суурь: 0,8м x 1,4м x 1,2м

Нүх: 1,5м3


Агааржуулагч: 2,5м Ø200мм



## Онцлог

Нүхэн жорлонгийн адил бүхээг, нүхнээс бүрдэнэ. Гол онцлог нь ус хэрэглэх бөгөөд ялгадсыг усны урсгалаар нүх уруу хөөх зарчмаар ажилладаг

## Хийц бүтээц



## Ашиглаж болох материал

Бүхээг: модон хавтан, магнезит хавтан  
Агааржуулагч: PVC хоолой  
Нүхний доторлогоо: тоосго, бетон, эсвэл төмөр юмкость

## Ашиглаж болох материал

Бүхээг: модон хавтан, магнезит хавтан  
Өтгөн хураах сав: 150л багтаамжтай хуванцар сав  
Агааржуулагч: PVC хоолой  
Суултуур: шээс тусгaaрлагчтай модон суултуур

## Онцлог

Энэ жорлон нь ээлжлэн ашиглах 2 суурьтай бөгөөд ашиглахгүй өнжөөж байгаа суурин дахь ялгадсыг үртэс, үns гэх мэт хуурай бодис мөн агааржуулалтын тусламжтайгаар усгүйжүүлж, хатаах зарчимтай



## Хийц бүтээц

Ээлжлэн ашиглах 2 суурь, дундын 1 бүхээгтэй. 1 суурийг дунджаар 1-2 жил ашиглах бөгөөд дүүрсэн үед нөгөө суурийг ашиглана. Суурийн арын хэсгийг нарны тусгальын зүг харуулан 45°C<sup>o</sup> налуутай хийж хаалгыг дулаан дамжуулах материалыар хийнэ. Шалыг битүү шаллаж суурь тус бүрд тус тусдаа бие засах нүх гаргана.

## Ашиглаж болох материал

Суурь: Тоосго, блок  
Бүхээг: модон хавтан, магнезит хавтан  
Агааржуулагч: PVC хоолой  
Суурийн хаалга: төмөр, шил  
Суултуур: модон суултуур

## ТАНЫ ЭРҮҮЛ МЭНДЭД

ээлтэй сонголт



## Жорлонгоо сайжруулахын ач холбогдол юу вэ?

- Халдварт өвчинөөс сэргийлнэ
- Цэвэр, тав тухтай амьдрана
- Хүрээлэн буй орчныг(хөрс, гүний ус) бохирдуулахгүй.

Таньд санал болгосон эдгээр хувилбаруудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах цахим хуудсуудад хандана уу.

[www.washaction.mn](http://www.washaction.mn)

[www.phi.gov.mn](http://www.phi.gov.mn)

[www.redcross.mn](http://www.redcross.mn)

Монгол орны цаг агаар, хөрсний онцлог байдалд тохирсон дараах 4 төрлийн жорлонгийн загваруудаас та өөрийн гэр бүлийн хэрэгцээнд нийцүүлэн сонгож, эрүүл тав тухтай амьдрах орчноо бүрдүүлээрэй